



Тусгай дугаар

Г.Сайханбаяр: ТА БҮХНЭЭС ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЦААШДЫН ХӨГЖИЛ ИХЭЭХЭН ХАМААРНА

2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ТАЙЛАНГИЙН ХУРАЛД МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Г.САЙХАНБАЯРЫН ТАВЬСАН ИЛТГЭЛИЙГ БҮРЭН ЭХЭЭР НЬ УНШИГЧ ТА БҮХЭНД ТОЛИЛУУЛЖ БАЙНА.



Эрхэм генерал, офицер, ахлагч, ажилтан албан хаагчид аа!

Та бүхний амрыг эрье. ЗХЖШ-ын 2021 оны үйл ажиллагааны тайлангийн хуралд биечлэн оролцож, Та бүхэнтэй уулзаж байгаадаа баяртай байна.

Тайлангийн хуралд тавигдаж байгаа илтгэл, дүнгээс харахад 2021 он Зэвсэгт хүчний хувьд нэлээд ажлыг амжуулсан, амжилт бүтээл дүүрэн жил байсныг харуулж байна.

Улс орны эдийн засгийн байдал, цар тахлын хүндрэлтэй нөхцөл зэргээс шалтгаалан зарим нэг томоохон төлөвлөгөөт арга хэмжээнүүд тасалдсан хэдий ч “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичигт тусгасан “Мэргэжлийн цэрэгт суурилсан, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлж бэхжүүлэх” зорилтыг хангахад ахиц гаргасан, түүхэн онцлог жил боллоо.

2021 он манай улсын хувьд олон түүхт ойнууд давхацсан онцлог жил байсан бөгөөд үүний нэг нь Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой тохиосон явдал юм.

Бид бүхэн энэ онд түүхт ойгоо ёслол төгөлдөр тэмдэглэсэн, шинэ төрлийн цэргийн командлалуудын үйл ажиллагааг жигдрүүлсэн, Зэвсэгт хүчний дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг батлуулж, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон, гадаад хамтын ажиллагаагаа идэвхжүүлсэн, энхийг дэмжих ажиллагаанд оролцох төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэх энхийн алхмуудаа амжилттай хэрэгжүүлсэн, анх удаа дотооддоо цэргийн зориулалттай зарим төрлийн цэргийн техник, хэрэгслийг туршин үйлдвэрлэсэн, улс орныхоо стратегийн бүтээн байгуулалтын болон бусад ажилд манлайлан оролцсон, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудаа жишиг хотхон, эко ногоон орчин болгох ажлын эхлэлийг амжилттай тавьсан зэргийг дурдахад таатай байна.

Түүнчлэн Монгол Улсын Зэвсэгт хүчин түүхт 100 жилийн ойгоороо Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн зарлигаар төрийн дээд шагнал, тэргүүн зэргийн “Чингис хаан одон” хүртсэн явдал нь батлан хамгаалах, Зэвсэгт хүчинд алба хааж буй генерал, офицер, ахлагч, ажилтан албан хаагчид, хугацаат болон цэргийн гэрээт алба хаагчид, энхийг сахиулагчид, үе үеийн ахмад дайчид, бэлтгэл болон чөлөөнд гарсан ахмадууд та бүхнийг Монгол эх орон, ард түмнийхээ эрх чөлөө, тусгаар тогтнолыг батлан хамгаалах болон даян дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах эрхэм үйлс, бахархам

амжилтыг төрийн дээд удирдлагаас үнэлсэн түүхэн үйл явдал болсныг энд онцлон тэмдэглэхийг хүсэж байна.

Одоо Та бүхэнд Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хэмжээнд 2021 онд хийж хэрэгжүүлсэн зарим онцлог ажил, арга хэмжээний талаар товчхон мэдээлэл өгье гэж бодож байна. 2014 оноос салбарынхаа хууль, эрх зүйн орчныг сайжруулах, улам төгөлдөржүүлэх ажлыг хийж эхэлсэн. Энэ хүрээнд Монгол Улсын төрөөс батлан хамгаалах талаар баримтлах бодлого, салбарынхаа голлох хуулиудаа шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг шат дараалан хэрэгжүүлж, тодорхой амжилтад хүрээд байна. Уг арга хэмжээ үргэлжилж, 2021 оны эхээр “Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийг УИХ-аар батлуулж, “Зэвсэгт хүчний хөгжлийн сан”-г Засгийн газрын тусгай сангийн төрөлд хамааруулж, бүрдүүлэлт, зарцуулалтын онцлогтой холбогдсон харилцааг Зэвсэгт хүчний тухай хуулиар, нийтлэг харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулах эрх зүйн зохицуулалттай болгосон.

Энэ нь Зэвсэгт хүчний өмнө тулгамдаад байгаа зэвсэглэл, техникийн шинэчлэлийг хийх, бэлэн байдал, сургалт бэлтгэлийн түвшнийг дээшлүүлэх, бие бүрэлдэхүүний ажиллаж, амьдрах орчин нөхцөл, нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэхэд онцгой чухал алхам болж, цаашид дээрх тулгамдсан ажил, арга хэмжээнүүдээ хэрэгжүүлэх маш том боломж бүрдсэн.

Зэвсэгт хүчний Цэргийн тагнуулын газар 2015 онд Тагнуулын ерөнхий газрын харьяанд шилжсэнийг Та бүхэн мэдэж байгаа. Энэ нь тухайн үеийн төр, засгийн удирдлагын буруу бодлого, шийдвэр байсан нь өнгөрсөн хугацаанд харагдлаа. Тагнуулгүй Зэвсэгт хүчин гэж хаана ч байхгүй.

Иймээс “Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийг санаачлан боловсруулж, улмаар 12 дугаар сарын 01-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн. Одоогоор Улсын Их Хуралд өргөн барихаар бэлэн болоод байгаа бөгөөд намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ. Энэ хууль батлагдсанаар Зэвсэгт хүчин цэргийн мэргэжлийн тагнуулын байгууллагатай болно.

Мөн “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг УИХ-ын намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэн батлуулахаар ажиллаж байна. Хууль батлагдсанаар хуулийн үйлчлэлд

хамаарах байгууллагын алба хаагчид, тэр дундаа эмэгтэй цэргийн алба хаагчидтай холбоотой эрх зүйн байдал, нийгмийн баталгаа улам сайжрах юм.

Цаашид 2022 онд батлан хамгаалах эрх зүйн шинэчлэл, салбарын хууль тогтоомжийг улам төгөлдөржүүлэх арга хэмжээний хүрээнд дараах хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулна. Тухайлбал,

– “Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Цэргийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулиар цэргийн цолны болон цэргийн дүрэмт хувцас хэрэглэхтэй холбогдсон эрх зүйн харилцааг боловсронгуй болгох зохицуулалтуудыг нарийвчлан зааж өгнө;

– “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулиар цэргийн алба хаагчдын эрх зүйн болон нийгмийн хамгаалалтай холбогдсон зохицуулалтыг боловсронгуй болгож, хуулийн давхардал, хийдлийг арилгах, цэргийн албыг биеэр болон хуульд заасан бусад хэлбэрээр хаах иргэдийн хүсэл сонирхол, эрмэлзлийг нэмэгдүүлэх, хугацаат цэргийн алба хаахтай холбоотой болон хаасан иргэдэд хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг тусгана;

– “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулиар Монгол Улсаас НҮБ-ын болон олон улсын бусад ажиллагаанд оролцох төрлийг нэмэгдүүлэх, энхийг дэмжих ажиллагааны удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, үүрэг гүйцэтгэх хугацаа, цэргийн багийг эгүүлэн татахтай холбогдсон эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тусгах юм;

– Мөн “Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулиар Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэрэг, Кибер аюулгүй байдлын цэрэг болон Цэргийн тагнуулын байгууллагын төсвийг УИХ-ын Тусгай хяналтын дэд хорооноос хянаж санал болгосноор тусгай зүйл болгон баталж байх эрх зүйн зохицуулалтыг тусгаж, батлан хамгаалах асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсвийн зарим хэсгийг тусгай журмаар УИХ хэлэлцэн баталдаг болох юм;

– Боловсролын багц хуулийн төслийн “Боловсролын ерөнхий хууль”, “Дээд боловсролын тухай”, “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай” хуулийн төсөлд Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн сургалтын үйл ажиллагааг явуулахад нэн шаардлагатай эрх зүйн зохицуулалт, түүн дотроо ҮБХИС түүний харьяа сургуулиудын эрх, статус анх удаа хуульчлагдана;

– “Зөвшөөрлийн тухай” (шинэчилсэн найруулга) хуулийн төсөлд цэргийн зориулалттай зэвсэглэл, техник, галт хэрэгслийг импортлох, экспортлох зөвшөөрөл болон Зэвсэгт хүчний Агаарын цэргийн үйл ажиллагаатай холбогдох зарим зөвшөөрөл олгох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгуулан батлуулна;

– Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль-д нэмэлт, өөрчлөлт оруулах хуулиар батлан хамгаалах зориулалтаар импортоор оруулж ирж байгаа барааг зарим татвараас чөлөөлөхтэй холбогдсон эрх зүйн зохицуулалтыг бий болгоно;

– “Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулиар батлан хамгаалах салбарт гаднын тусламж, дэмжлэгээр оруулж ирж байгаа буцалтгүй тусламжийн бараа болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан цэргийн зэвсэглэл, бусад бараа материалыг

хил, гаалиар нэвтрүүлэхдээ түргэвчилсэн горимоор хүлээн авах болон олон улсын цэргийн хээрийн сургууль, сургалт дадлагад оролцохоор ирсэн гадаад улсын цэргийн багийн зэвсэглэл, техник хэрэгслийг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд байршуулах барааны мөнгөн дүнтэй холбогдох асуудлыг эрхэн шийдвэрлэхтэй холбогдсон зохицуулалтыг бий болгоно;

– “Газрын төлбөрийн тухай хууль”-д нэмэлт оруулах тухай хуулиар улсын төсвөөс санхүүждэг Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбар хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө газрын төлбөр төлөхгүй байх эрх зүйн зохицуулалтыг бий болгох зэрэг болно.

Улмаар Бид “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд “Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ” гэсэн үндсэн зорилтыг дэвшүүлж, 9 дэд зорилт 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган ажиллаж байна.

Мөн энэ оны эхээр “Батлан хамгаалахын стратеги төлөвлөгөө (2021-2024)”, “Зэвсэгт хүчний байгуулалтыг 2024 он хүртэл хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулан харьяа агентлаг, төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, салбар, байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр Батлан хамгаалахын сайдын бүрэн эрхийн хүрээнд баталгаажуулан хэрэгжүүлж эхэлсэн.

Дээрх болон Зэвсэгт хүчний дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусган зорилтууд, ажил, арга хэмжээнүүдийг тодорхойлогдсон цаг хугацаанд нь хэрэгжүүлэхэд бүх шатны дарга нар, албан тушаалтнууд анхаарч, идэвх санаачилгатай ажиллах хэрэгтэй юм.

Сайд миний бие салбарынхаа гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар Батлан хамгаалах Зэвсэгт хүчнийхээ хөгжилд бодитой өөрчлөлт, шинэчлэлт хийхэд бодлогоор анхаарал хандуулан ажиллаж байна.

Уг бодлогын нэг хэсэг нь хамтын ажиллагаатай гадаад улсуудтай байгуулсан “Цэргийн болон цэрэг-техникийн хамтын ажиллагаа”-г өргөжүүлэх замаар гэрээ, хэлэлцээрүүдийг тогтмолжуулж, үр дүнд нь зэвсэглэл, цэргийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөө шинэчлэх ажил юм.

Энэ оны 6 дугаар сард болсон “Олон улсын аюулгүй байдлын Москвагийн 9 дүгээр бага хурал”-д оролцох үеэр ОХУ-ын Батлан хамгаалахын сайд С.К.Шойгутай хоёр талын уулзалт хийж, манай Зэвсэгт хүчинд нэн шаардлагатай зэвсэглэл, цэргийн зориулалттай техник, тоног төхөөрөмжийг цэрэг-техникийн буцалтгүй тусламжийн хүрээнд үзүүлэх талаар хүсэлт тавьж, тохиролцсоны үр дүнд сургалт-байлдааны МиГ-29УБ сөнөөгч онгоцнууд, Ми-8, Ми-24 загварын нисдэг тэрэгний техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг нийлүүлэх асуудлыг шийдсэн.

Мөн 2021 онд ОХУ, БНХАУ, АНУ, ХБНГУ, БНПУ, Япон Улсаас 70-аад тэрбум төгрөгийн үнэ бүхий 20 гаруй нэр төрлийн зэвсэг, галт хэрэгсэл, цэргийн техник, хээрийн эмнэлэг, тусгай зориулалтын, радио холбооны, сургалтын, ууланд авиралтын техник, тоног төхөөрөмжийг гэрээ, хэлэлцээрийн хүрээнд болон буцалтгүй тусламжаар авч, Зэвсэгт хүчний зэвсэглэл, техник хэрэгслийг

шинэчлэн сайжруулах мөн НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцуулахаар бэлтгэж буй салбар, нэгжийн техник, хэрэгслийн нөхөн хангалтыг бүрдүүлсэн.

Мөн 11 дүгээр сард БНТУ-д хийсэн албан ёсны айлчлалын хүрээнд яамны харьяа “Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл” ТӨААТҮГ, Туркийн Үндэсний Батлан хамгаалах яамны харьяа “МКЕ” ТӨК хоорондын “Галт хэрэгслийн үйлдвэрийн шугам байгуулах тухай гэрээ”-г байгуулснаас гадна 2022 оны улсын төсөвт “Бага бууны сумны үйлдвэр” байгуулахад шаардагдах хөрөнгийг Батлан хамгаалахын сайдын багцад тусгуулаад байна.

Улмаар 12 дугаар сарын 07-08-нд БНСУ-д зохион байгуулагдсан НҮБ-ын цэрэг илгээгч орнуудын Батлан хамгаалахын сайд нарын хуралд цахимаар оролцож, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны талаар Монгол Улсын баримталж буй бодлого, байр суурь, цаашид авч хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны талаар тодорхой танилцууллаа.

Мөн цар тахалтай амаргүй цаг үед хоёр хөршийн батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний өндөр албан тушаалтнууд манай улсад айлчилсан нь гадаад хамтын ажиллагааг идэвхжүүлсэн онцлог үйл явдал болсон. БНХАУ-ын Төрийн зөвлөлийн гишүүн, Батлан хамгаалахын сайд хурандаа генерал Вэй Фөнхө, ОХУ-ын Батлан хамгаалахын нэгдүгээр орлогч сайд, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга армийн генерал В.В.Герасимов нарын албан ёсны айлчлалын хүрээнд батлан хамгаалах харилцааг хөгжүүлэх, цэргийн болон цэрэг-техникийн хамтын ажиллагааны өргөн чиглэлээр харилцан итгэлцсэн, нээлттэй, дэлгэрэнгүй яриа, хэлэлцээр хийсэн нь ихээхэн үр дүнтэй арга хэмжээ болсон юм.

Монгол Улсын нэр хүнд, Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх бэлэн байдал, чадавхад асар их нөлөө үзүүлж байгаа нэг асуудал бол НҮБ-д цэрэг хандивлагч орны хувьд хүлээсэн үүргээ биелүүлж, даян дэлхийн амар амгаланг тогтоох энхийн үйлсэд оролцож буй явдал юм.

Бид цаашид НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд оролцох оролцоогоо нэмэгдүүлэх, төрөл, хэлбэрийг баяжуулах, төрөл, тусгай мэргэжлийн салбар, нэгжүүдийг бие даан үүрэг гүйцэтгүүлэх асуудлыг бодлогын түвшинд тодорхойлж, шинэчлэх шаардлагатай.

Уг асуудлын хүрээнд НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчнээс “Түргэн байрлах хүчний ротыг оролцуулах бэлтгэлийг хангах тухай” асуудлыг 2021 оны 11 дүгээр сарын Засгийн газрын болон ҮАБЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн зохих шийдвэрийг гаргууллаа.

Мөн Монгол Улсын Зэвсэгт хүчнээс энхийг дэмжих ажиллагаанд “Цэргийн хээрийн II шатны эмнэлгийг оролцуулах бэлтгэлийг хангах тухай” асуудлыг Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн шийдвэрийг гаргасан. Үүнээс гадна “Инженерийн рот”-ыг оролцуулах бэлтгэл ажил өнөөдөр ч үргэлжлэн явагдаж байгаа Та бүхэн мэднэ.

Дээрх НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах салбар, нэгжүүдийн бэлтгэлийг бүрэн хангаж, НҮБ-ын Үнэлгээ, зөвлөмжийн бүлэгт амжилттай шалгуулан бэлэн байдлын системд бүртгүүлж, ажиллагааны газар оронд илгээн үүрэг гүйцэтгүүлж эхэлсэнээр Бид бүхний өмнөө тавьсан нэг томоохон зорилт хэрэгжиж, дэвшүүлж байгаа дараагийн зорилтдоо чиглэсэн үр дүнд хүрэх эхлэл болно.

Г.Сайханбаяр: ТА БҮХНЭЭС ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЦААШДЫН ХӨГЖИЛ ИХЭЭХЭН ХАМААРНА

(Түрүүч нь эхний нүүрт)

Ирэх жил Монгол Улс НҮБ-ын мандаттай энхийг сахиулах ажиллагаанд цэргээ илгээж, оролцуулж эхэлсний 20 жилийн ой болно. Энэ ойн бэлтгэл ажилд ач холбогдол өгч, сайтар ханган тус ойг ёслол төгөлдөр тэмдэглэх учиртай. Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх НҮБ-ын Ерөнхий ассамблейд үг хэлэхдээ цаашид Монгол Улсын НҮБ-ын мандаттай энхийг сахиулах ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлэх түүн дотроо эмэгтэй алба хаагчдын тоог нэмэгдүүлэх, дэлхийн энхийг сахиулагч эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг өөрийн улсдаа зохион байгуулах талаар хөндсөн.

Бид НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд эмэгтэй цэргийн алба хаагчдын оролцоо, тэдний туршлага, сургамжийн талаарх олон улсын чуулга уулзалтыг 2022 онд Улаанбаатар хотноо анх удаа зохион байгуулах болно. Энэ нь Монгол Улсын төр, Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагааны идэвхтэй үйл ажиллагааны нэг тод илрэл болох юм.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг "Алсын хараа-2050"-д "Батлан хамгаалах тогтолцоог төгөлдөржүүлэн, технологийн дэвшлийг нэвтрүүлж, батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх" гэсэн том зорилтыг дэвшүүлсэн.

2021 онд батлан хамгаалах салбар "Үйлдвэрлэгч", "Бүтээн байгуулагч" салбар байх зорилт тавин ажиллаж, тодорхой амжилтад хүрсэн гэж үзэж байгаа. Тухайлбал, Зэвсэгт хүчний цэргийн инженер, техникийн мэргэжилтнүүдийн хүчээр байлдааны болон хөнгөн хуягласан, тусгай зориулалтын 3 төрлийн "Мазаалай-3 нэгж", "Чоно-12 нэгж", "Хилэнцэт-10 нэгж"/25 нэгж авто хуягт техник, 3 нэгж нисгэгчгүй нисэх хэрэгсэл /Ел-1, Ел-2, Хяналт-1/, 500-800 км-т холбоо барих боломжтой богино долгионы дунд чадлын "Монорадио-1000" станц, төрөл бүрийн программуудыг дотооддоо анх удаа үйлдвэрлэж, Зэвсэгт хүчний зэвсэглэлд шилжүүлээ. Бид өөрсдийнхөө нөөц бололцоог ашиглан орчин үеийн технологийн ололт, шийдлийг тодорхой хэмжээнд нутагшуулан нэвтрүүлэх, дотооддоо цэргийн техник, хэрэгсэлээ үйлдвэрлэх боломж байгаа нь харагдсан сайдын хувьд сэтгэл нэн хангалуун байгаагаа хэлье. Цаашид эрдэм шинжилгээний байгууллагын материаллаг бааз, эрдэмтэн, судлаачдын оюуны чадавхад түшиглэн улс орны хөгжилд бодитой хувь нэмэр оруулахуйц аюулгүй байдал, батлан хамгаалах эрх ашигт нийцсэн салбарын болон салбар дундын судалгаа, хөгжүүлэлт, туршилтын төслүүдийг боловсруулан хэрэгжүүлж, Зэвсэгт хүчний туршилт судалгааны төвүүдэд хийгдсэн шинэ бүтээл, санал, санаачилга, инновацыг цэргийн хэрэг, практикт нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэхэд анхаарч, бүхий л талаар дэмжих болно.

Зэвсэгт хүчин улс орныг хөгжүүлэх стратегийн бүтээн байгуулалтын ажилд идэвхтэй өндөр ачаалалтай оролцож, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416,1 км төмөр замын далангийн суурийн ажлыг 100 хувь, дээд суурийн тодорхой хэсгийг хийж дуусгасан, "Газрын тос боловсруулах үйлдвэр"-ийн ажилчдын 5 блок барилга, бусад байгууламжийг барих,

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын ажлын доголдолтой хэсэгт орж ажиллаж эхэлсэн, улс орны хэмжээний ургац хураалтын ажилд 3000-аад цэргийн алба хаагч ажиллаж, "Тавантолгой түлш" ТӨҮГ-ын түүхий эдийг тээвэрлэх ажилд 190 орчим цэргийн алба хаагч, 60-аад нэгж өөрөө буулгагч автомашин 2 сар гаруй хугацаатай үүргээ амжилттай гүйцэтгэж, "Хөвсгөл нуур"-ын экосистемийг хамгаалах, "Сүхбаатар" хөлөг онгоцыг далайн зэрэгт татан гаргах ажлыг Зэвсэгт хүчний цэргийн инженерүүд манлайлан, өөрсдийн техникээр хийсэн зэрэг нь улс орныхоо эдийн засгийн болон өнөөгийн хүнд хэцүү цаг үед Зэвсэгт хүчин үүрэг гүйцэтгэхэд бэлэн байгааг илтгэсэн чухал арга хэмжээ боллоо. Түүнчлэн улсын хилийн боомт дээр үүссэн нөхцөл байдлыг зохицуулах, журам сахиулах үүргийг 50 гаруй цэргийн алба хаагч өнгөрсөн оны 6 дугаар сараас хойш Замын-Үүд боомтод 3 сар, 200 гаруй алба хаагч хил дээр бөөгнөрсөн түүхий эд, бараа материалыг ачих буулгах ажлыг 3 сарын турш хийж, Гашуун сухайт боомтод өнгөрсөн оны 9 дүгээр сараас өнөөдрийг хүртэл, дэмжлэг үзүүлж ажилласаар байна. "Зэвсэгт хүчин хэзээ нэгэн цагт хэрэгтэй биш хэзээ ч үүрэг гүйцэтгэх бэлэн байдалтай хүчин байх ёстой" гэж би сайдаар томилогдсонхоо дараа бодлогоо тодорхойлохдоо онцолж байсан Та бүхэн санаж байгаа байх. Энэ талаар өнгөрсөн онд нийгэмд чиглэж бидний хийсэн олон ажил, арга хэмжээ үүнийг нотолж байна. Цаашид ч бид дэмжлэг туслалцаа үзүүлэхэд бэлэн байх шаардлагатай.

Цаашид Зэвсэгт хүчний Архангай, Говь-Алтай аймгуудад барилга, инженерийн анги байгуулах ажлыг эрчимжүүлж, барилга-инженерийн бүх ангид үзэмж төмөр зам, авто зам, барилга үйлдвэрлэл, цахилгаан станцын барилга зэрэг улс орныг хөгжүүлэх стратегийн бүтээн байгуулалтын ажилд үргэлжлүүлэн оролцуулна.

Үүний зэрэгцээ цөлжилттэй тэмцэх, экологийн үйлсэд Зэвсэгт хүчний алба хаагчдыг оролцуулж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд батлан хамгаалах салбар нэгдэж, 2030 он гэхэд 22 сая модыг тарьж ургуулахаар холбогдох тооцоо, судалгааг хийж хэрэгжүүлж эхлээд байна.

Цэргийн төв эмнэлэг нь 2020 оны 11 дүгээр сараас эхлэн "Ковид-19"-ын онош нь батлагдсан иргэдийг хүлээн авч, өнөөдрийн байдлаар 7580 иргэнд эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэн, дараагийн хяналтад шилжүүлсэн. Мөн коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтын хүрээнд Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нийт алба хаагчдын 96 хувь нь I тун, 98 хувь нь II тунд, 81 хувь нь дархлаа сэргээх III тунд тус тус хамрагдаад байгаа бөгөөд нийгмийн хариуцлагын хүрээнд хүнс, худалдааны салбарын 6300, өмнөд бүсэд байрлах уул уурхайн 44 байгууллага, 113 нэгжийн 17434 ажилтан, алба хаагчдад дархлаажуулалтыг зохион байгууллаа.

Манай салбар бидний хувьд батлан хамгаалахын сайдын төсвийн багцын улсын төсөвт эзлэх хувийг нэмэгдүүлэх замаар хөгжлийн төсөв болгох асуудал байнга чухлаар



тавигдаж ирсэн.

Батлан хамгаалах салбарын 2021 оны төсөв улсын төсвийн зарлагын 2 хувьтай тэнцүү байсан бол төсвийн шинэчлэлтэй холбогдуулан 2022 оны төсөв 2,4 хувь болж өссөн.

Тухайлбал, ЗХЖШ-ын төсөв урд оны төсвөөс 18 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан нь өмнөх жилүүдэд хүрэлцэхгүй байсан цалин хөлс, нормт хувцасны хангалт, тогтмол болон бусад зардлууд тодорхой хэмжээгээр шийдэгдэх нөхцөл бүрдсэн.

Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалт нийт 7,9 тэрбум төгрөгөөр, үүнээс их засварын ажлын хөрөнгө оруулалтын төсөв даруй 1,9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан нь Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудын барилга, байгууламжуудад зайлшгүй шаардлагатай урсгал болон их засвар хийхэд багагүй дэмжлэг үзүүлэх ач холбогдолтой болно. Дээрх хийж хэрэгжүүлсэн томоохон ажил, арга хэмжээнүүдээс дүгнэхэд бидэнд хийсэн ажил их байна. Харин хэн нэгний санамсар болгоомжгүй, хариуцлагагүй үйлдлээс болж салбарын нэр хүнд унах ёсгүй. Сайны хажуугаар саар гэгчээр цэргийн алба, цэргийн хөдөлмөрийн болон хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой осол, зөрчил арилахгүй байна.

Энэ талаар БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлалуудаас нэгтгэл, анги, салбар, байгууллагуудад өгсөн үүрэг, даалгавар, санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмж чамлахааргүй олон байгаа ч гагцхүү тэдгээрийг ажил хэрэг болгон үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, хэвшүүлэх бүх шатны захирагч, дарга, албан тушаалтнуудын ажлын хариуцлагыг дээшлүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих, дотоодын хяналт шалгалтын чанар, үр нөлөөг эрс сайжруулах, уг асуудалд цэргийн алба хаагч бүр ухамсартай хандахад онцгой анхаарч ажиллах шаардлагатай байна.

Цэргийн алба хаагчдыг соён гэгээрүүлэх, сэтгэл зүйн ажлыг эрчимжүүлэх хэрэгтэй байна. Энэ ч үүднээс сэтгэл зүйч мэргэжлээр их, дээд сургууль төгссөн залуусыг "Цэргийн сэтгэл зүйч", "Соёл хүмүүжлийн ажилтан"-аар бэлтгэх мэргэшүүлэх сургалтыг Үндэсний батлан хамгаалахын их сургуульд 2021 оны 12 дугаар сарын 10-наас эхлэн 3 сарын хугацаатай зохион байгуулж байна.

"Батлан хамгаалах-Иргэний хяналт 1800-1144"

тусгай дугаараар Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, цэргийн нэгтгэл, анги, салбартай холбоотой аливаа мэдээллийг нээлттэй, 24 цагийн турш хүлээн авч, холбогдох арга хэмжээг авч байгааг дахин сануулья.

Эрхэм генерал, офицер, ахлагч, ажилтан албан хаагчид аа!

Батлан хамгаалахын сайдын хувьд ирэх 2022 оныг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт батлан хамгаалах талаар туссан томоохон зорилт, арга хэмжээнүүд бодит ажил хэрэг болсон, Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилт улам эрчимжсэн, их бүтээн байгуулалт өрнөсөн, Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиглагаанд оролцох оролцоо нэмэгдсэн, зэвсэглэл, цэргийн техникийн шинэчлэлт, алба хаагчдын маань нийгмийн хамгааллын асуудалд тодорхой ахиц гарсан сайхан жил болно гэж харж байгаа.

Иймд Та бүхэнд ирж буй 2022 онд ажил, албандаа анхаарч ажиллах зарим зөвлөмж, үүрэг, чиглэлийг өгье.

Энэхүү танхимд сууж байгаа Та бүхнээс Зэвсэгт хүчний цаашдын хөгжил, дэвшил, сайн сайхан бүхэн ихээхэн хамаарна. Яагаад гэвэл Та бүгд Зэвсэгт хүчний уураг тархи болсон Жанжин штаб, төрлийн цэргийн командлалуудын алба хаагчид. Шинэчлэлт, өөрчлөлтийг өөрсдөөс эхлэх хэрэгтэй. Ажил, албандаа эзэн нь болсон, мэдлэг мэргэжлээрээ бусдыгаа манлайлагчид нь Та нар байх ёстой;

Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх дунд хугацааны бодлогын баримт бичигт туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд бүх шатны дарга нар, алба хаагчид онцгойлон анхаарч ажиллах;

Зэвсэгт хүчний бэлэн байдлыг дээшлүүлэх, байлдааны болон хуулиар хүлээсэн чиг үүргийг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэхэд бүх талаар анхаарч бодит ахиц дэвшил гаргах;

Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэхэд онцгойлон анхаарна. Шинэ төрлийн техник, зэвсэглэл үйлдвэрлэх ажлыг үргэлжлүүлэн бодлогоор дэмжинэ. Зэвсэг, цэргийн техникийн үйлчилгээ, засварыг үе шат, тодорхой хуваарьтайгаар тасралтгүй хийх;

Зэвсэгт хүчин материаллаг зүйлийг бус, хүн үйлдвэрлэгч салбар юм. Өөрөөр хэлбэл эцэг, эхийн

гар дээрээс ирсэн залуусыг хүмүүжүүлдэг, сургадаг, өрхийн тэргүүнийг бэлтгэдэг, иргэнийг төлөвшүүлдэг салбар.

Иймд цэргийн алба хаагчидтай цэргийн дүрмийн дагуу харьцах, зөвхөн хуульд нийцсэн тушаал өгч, хэрэгжилтийг шаарддаг байх, цэргийн сургалт бэлтгэлийг эрчимжүүлэх, хугацаат цэргийн алба хаагч, офицер, ахлагч нарт энгийн мэргэжил эзэмшүүлэхэд бүх анги, командлал, удирдлагын байгууллага, штаб, хүний нөөцийн албад анхаарах хэрэгтэй;

Хугацаат болон цэргийн гэрээт алба хаагч, ахлагч, офицеруудад гадаад хэл, компьютер, нийгмийн тухай мэдлэгийг эзэмшүүлэхэд бодлогоор анхаарч үр дүн гаргах.

Шинээр байгуулагдсан төрлийн цэргийн командлалууд, удирдах газрыг бүхий л талаар бэхжүүлэхэд ЗХЖШ-ын удирдлага онцгойлон анхаарах хэрэгтэй. Үүнд Батлан хамгаалах яам ч анхааран ажиллана;

2022 онд Зэвсэгт хүчнээс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах цэргийн баг, алба хаагчдыг бэлтгэх, сонгон шалгаруулалтыг зөв шударга явуулах, олон улсын хамтарсан сургалт, дадлага, уралдаан тэмцээний бэлтгэлийг сайтар хангаж, оролцуулах;

Мөн НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцуулахаар бэлтгэж буй "Түргэн байрлах хүчний рот", "Инженерийн рот", "Цэргийн хэргийн II шатны эмнэлэг"-ийн бэлтгэлийг бүрэн хангах;

Барилга-инженерийн цэргийн ангиудыг улс орныг хөгжүүлэх стратегийн бүтээн байгуулалтын ажилд үргэлжлүүлэн оролцуулах, хөдөлмөр хамгаалал, техникийн бэлэн байдлыг сайтар хангах;

О ф и ц е р у д ы н мэргэшил, үр чадварын түвшин, ёс зүйн төлөвшил, хувь хүний хандлагыг тогтоох, мэргэжлийн цэрэгт тавигдах шаардлага, шалгуурыг тодотгох зорилгоор Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбар, байгууллагын офицер, ахлагчийн мэргэшил, үр чадвар, ёс зүйн түвшнийг тогтоох үзлэгийг Зэвсэгт хүчний Жанжин штаб энэ онд тусгай төлөвлөгөөний дагуу явуулж дууссан.

Энэхүү цаг хугацаа, хөрөнгө хүч шаардсан ажил тодорхой үр дүнтэй, ач холбогдолтой байх ёстой. Тиймээс уг үзлэгийн үр дүн, түүнтэй уялдуулан цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох талаарх саналыг Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанд оруулж танилцуулах;

Цэргийн алба хаагчийн бие бяддын бэлтгэлжилт, чадварыг дээшлүүлэхэд онцгойлон анхаарахыг үүрэг болгож байна;

Монгол Улсын Ерөнхийлөгчийн шийдвэрээр "Цэргийн цол олгох журам"-ыг боловсронгуй болгох ажил үндсэндээ дууссан. Цаашид хугацаат цэргийн алба хаах хугацаа, цэргийн сургалтын тогтолцоонд бодлогын өөрчлөлт оруулах, цэргийн дүрэмт хувцасны шинэчлэлийг хийх санал боловсруулах үүрэг өгч байна;

Цэргийн алба, сахилга зохион байгуулалтыг сайжруулах, гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнд тавих хяналтыг нэмэгдүүлэх зорилгоор хугацаат цэргийн алба хаагчидтай Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын цэргийн байр, танхим, шаардлагатай барилга, байгууламжийг бүрэн камержуулсан.

Энэхүү ажлыг үргэлжлүүлэн нэгтгэл, анги, салбарт хяналт шаардлагатай байрлалуудыг тогтоох, нэмж камержуулах, харуул, хоногийн манааны бие бүрэлдэхүүний үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх зэргээр холбогдох арга хэмжээг авах;

Зэвсэгт хүчний алба хаагчдын ёс зүй, шударга байдал, сахилга хариуцлага, ажил албандаа хандах "Хандлагаа өөрчилъё-хариуцлага татай байя" уриалгыг дэвшүүлж буй. Хариуцлага алдсан хэнтэй ч эвлэрэхгүй байж, дор бүрд нь хатуу арга хэмжээ авч байх;

Гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын амьдрах орчин нөхцөл, байр, халуун, хүйтэн ус зэрэг наад захын хэрэгцээний чанарыг дээшлүүлэхэд бодитой арга хэмжээ авч, Зэвсэгт хүчний нөхөн хангалтыг нэмэгдүүлэхэд анхаарах;

Ардын хувьсгалын 100, 101 жилийн ойн цэргийн ёслолын жагсаал, энхийг сахиулах ажиллагаанд цэргээ оролцуулж эхэлсний 20 жилийн ойг тэмдэглэх бэлтгэл ажлыг сайтар хангах;

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний командлагчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд батлан хамгаалах салбар нэгдэж, холбогдох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж эхэлсэн. Үүнд Зэвсэгт хүчний оролцоо маш чухал, бид тэргүүлэх байр суурьтай оролцох ёстойг онцгой анхаарч ажиллах.

Эцэст нь дүгнэхэд удирдлагын түвшинд гаргасан шийдвэрийг шат шатандаа нэг санаа зорилготойгоор хэрэгжүүлж ажиллах нь туйлын чухал бөгөөд албан тушаалтнуудын ухамсар, хандлага, сэтгэл, хичээл зүтгэлээс ихээхэн хамаарахыг ойлгож, түргэн шуурхай хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгож байна.

Ингээд Та бүхэндээ улирч буй онд хэрэгжүүлсэн ажил үйлсээ үргэлжлүүлэн бататгаж, 2022 ондоо илүү ихийг бүтээж, эх орноо батлан хамгаалах, Зэвсэгт хүчнээ хөгжүүлэх үйлсдээ улам өндөр амжилт гаргахыг хүсэн ерөөе.

Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүндээ шинэ оны мэндийг хувиасаа болон сайдын зөвлөлийн гишүүдийн нэрийн өмнөөс өргөн дэвшүүлж, эрүүл энх, аз жаргал, хамгийн сайн сайхныг хүсье.

Монгол цэргийн сүлд, хийморь үеийн үед мандан бадраг. Баярлалаа.

Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ

Батлан хамгаалах яам

Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС

"Соёмбо" сонин

"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.

* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018

Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn

Утас: 70001029, 3412 (дотуур)